



ОНЦГОЙ БАЙДЛЫН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2025 оны 10 сарын 31 өдөр

Дугаар А/446.

Улаанбаатар хот

Төлөвлөгөө батлах тухай


Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.1, 30.1.8, 30.1.19-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1.“Онцгой байдлын байгууллагын холбоо зохион байгуулах бэлэн байдлын төлөвлөгөө”-г хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллахыг төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын дарга, захирагч нарт үүрэг болгосугай.

3.Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Холбоо, мэдээллийн технологийн газар (хошууч М.Отгонпүрэв)-т даалгасугай.

ДАРГА,
ХОШУУЧ ГЕНЕРАЛ



Г.АРИУНБУЯН

Онцгой байдлын ерөнхий газрын даргын
2025 оны 10 дугаар сарын 31-ны өдрийн
тушаалын хавсралт



ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

УЛААНБААТАР ХОТ
2025 он

ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ

Нэг. Удиртгал

Хоёр. Зорилго

Гурав. Холбоо зохион байгуулалтын удирдлага, зохицуулалт

Дөрөв. Хүч, хэрэгслийн зохион байгуулалт

Тав. Холбоо зохион байгуулалтын бэлэн байдлын төлөвлөгөө

А. Холбоо зохион байгуулалтын бэлэн байдлыг хангах талаар

Б. Онцгой байдлын байгууллагын гамшгийн үед хэрэгжүүлэх арга хэмжээ

Зургаа. Харилцаа холбоог сэргээн засварлах арга хэмжээг зохион байгуулах

Долоо. Хяналт

Хавсралт

Хавсралт - 1. Гамшгийн үед төв, орон нутгийн онцгой байдлын байгууллагын холбооны хүч хэрэгслийг татан оролцуулах хуваарь

Хавсралт - 2. Цахим мэдээлэл дамжуулах бүдүүвч

Хавсралт - 3. Холбоо зохион байгуулах бүдүүвч

ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БЭЛЭН БАЙДЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нэг. Удиртгал

Гамшгийн үеийн харилцаа холбооны тогтвортой, тасралтгүй ажиллагаа нь Онцгой байдлын байгууллагын удирдлага, зохицуулалтыг хэрэгжүүлэх, мэдээлэл солилцоо болон хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах үндсэн нөхцөл болдог. Иймд энэхүү төлөвлөгөө нь гамшгийн үед холбооны системийг үр дүнтэйгээр зохион байгуулах бүтэц, бие бүрэлдэхүүн, үүрэг хариуцлагыг тодорхойлж, шаардлагатай нөөц холбоог ашиглахад чиглэсэн удирдлагын баримт бичиг болох юм.

Холбоо зохион байгуулалт нь удирдлагын системийн салшгүй бүрэлдэхүүн хэсэг бөгөөд мэдээ, мэдээллийг солилцоход тасралтгүй, найдвартай, шуурхай дамжуулах хүн, хүч хэрэгслийн хангалт дээр үндэслэгдэх бөгөөд тус төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхтэй холбогдсон хангалтын зардлыг улсын төсөвт тусгуулж, хэрэгжилтийг хангана.

Хоёр. Зорилго

Онцгой байдлын байгууллагын бүх шатны нэгжүүд болон гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа хүч, хэрэгслийн харилцан уялдааг хангах, бүх түвшинд харилцаа холбооны найдвартай, тасралтгүй ажиллагааг бүрдүүлэх, мэдээллийн урсгалыг шуурхай зохион байгуулах, удирдлага зохицуулалтын үр дүнтэй ажиллагааг дэмжихэд энэхүү төлөвлөгөөний зорилго оршино.

Хамрах хүрээ:

Энэхүү төлөвлөгөө нь Онцгой байдлын байгууллагын төв, орон нутгийн бүх шатны нэгжүүд, гамшгийн үед үүрэг гүйцэтгэх суурин болон хөдөлгөөнт холбооны зангилаа, мөн бусад чиг үүргийн байгууллагуудтай холбоо зохион байгуулах хүрээнд ашиглана.

Гурав. Холбоо зохион байгуулалтын удирдлага, зохицуулалт

3.1. Гамшгаас хамгаалах үйл ажиллагаанд холбоо зохион байгуулахдаа “Гамшгаас хамгаалах тухай хууль”, “Засгийн газрын 416, 417 дугаар тогтоолоор батлагдсан төлөвлөгөө”, “Монгол Улсын гамшгаас хамгаалах төлөвлөгөө”, “Онцгой комиссын шуурхай штабын ажиллах журам”, Мэдээлэл, харилцаа холбооны гамшгаас

хамгаалах улсын албаны төлөвлөгөө”, Онцгой байдлын байгууллагын “Ажиллагааны удирдлага, зохион байгуулалтын журам”, “Онцгой байдлын байгууллагын радио холбоо зохион байгуулах журам”, “Гамшгийн голомтод холбоо зохион байгуулах заавар”, “Онцгой байдлын байгууллагын салбар, нэгжийн холбооны системд тавигдах шаардлага” стандарт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн дүрэм болон бусад холбогдон гарсан эрх зүйн баримт бичгийг мөрдөж ажиллана.

3.2. Шуурхай удирдлагын төвүүдийн харилцан ажиллагааны холбоо зохион байгуулалт:

3.2.1. Үндэсний аюулгүй байдлыг хангах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай “Чиглэлийн төлөвлөгөө”-нд тусгагдсаны дагуу харилцан ажиллагааны холбоог зохион байгуулна.

3.2.2. Үндэсний болон бүс нутгийн түвшинд байгуулагдсан шуурхай удирдлагын төв хооронд мэдээлэл солилцох, удирдлагын шийдвэр дамжуулах зориулалт бүхий тусгай хэрэглээний радио холбооны нэгдсэн сувгаар холбоо зохион байгуулалтын тасралтгүй ажиллагааг хангана.

3.2.3. Харилцан ажиллагаатай байгууллагуудтай холбооны нэгдсэн стандарт, протокол, шифрлэлтийн дагуу мэдээлэл солилцооны дэг журмыг мөрдөж, тусгай эрхийн хяналтад холбоо зохион байгуулна.

3.2.4. Шуурхай штабт харилцан ажиллагааны холбоог хангах оператор томилгоожуулан байгууллага хоорондын мэдээллийг нэг цэгээс удирдан зохион байгуулах зохицуулалтыг хэрэгжүүлнэ.

3.2.5. Гамшгийн үед Мэдээлэл, харилцаа холбооны улсын албаны гамшгаас хамгаалах төлөвлөгөөг идэвхжүүлэх, олон улсын харилцаа холбооны дэмжлэгийг авах арга хэмжээг хэрэгжүүлнэ.

3.3. Салбар, нэгжийн харилцан ажиллагааны холбооны зохицуулалт:

Онцгой байдлын ерөнхий газрын харьяа Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн төв 119 дүгээр ангиас улсын хэмжээнд стратеги болон оперативын түвшинд удирдлагын холбоог зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.


3.3.1. Нийслэлийн Мэдээлэл шуурхай удирдлагын төв, шуурхай удирдлага 101,105 хэлтэс нь Улаанбаатарын бүсийн Онцгой байдлын газрын салбар, нэгжтэй оператив, тактикийн түвшинд холбоог зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангана.

3.3.2. Аймаг, орон нутгийн хэмжээнд Онцгой байдлын газар, хэлтсийн Шуурхай удирдлагын төв (Гал түймэр унтраах, аврах анги, Эрэн хайх, аврах анги, салбар, бүлэг) нь бүс, нутгийн хэмжээнд үүссэн гамшгийн голомтод тактик (бүлгийн)-ийн холбооны зохицуулалтыг хариуцна.

3.3.3. Гамшгийн үед анхдагч мэдээлэл хүлээн авахаас эхлэн удирдлага, зохицуулалтын үйл ажиллагааг идэвхжүүлж, мэдээлэл солилцох дараах дарааллын дагуу зохион байгуулна. Энэхүү үйл ажиллагаанд байгууллагын

хэмжээнд бүртгэлтэй харилцаа холбооны бүх төрлийн суваг (радио, утас, сансрын холбоо, интернэт сүлжээ)-ийг ашиглана.

ГАМШГИЙН ҮЕИЙН МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ, ДАМЖУУЛАХ ДАРААЛАЛ



3.4. Гамшгийн голомтын тактик (бүлгийн)-ийн холбооны зохицуулалт:

3.4.1. Гамшгийн голомтод хөдөлгөөнт холбооны зангилааг байрлуулж, харилцаа холбооны боломжит сувгаар оператив болон тактик (бүлгийн)-ийн холбоог зохион байгуулна.

3.4.2. Монгол Улсын Онцгой комиссын 2025 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн 01 дүгээр тоот тушаалаар баталсан “Ой хээрийн гал түймрээс урьдчилан сэргийлэх, тэмцэх арга хэмжээний удирдамж”-ийн 2 дугаар хавсралт–ыг үндэслэн удирдлагын шийдвэрийн дагуу төв, орон нутгийн зэргэлдээх сум, дүүргийн Онцгой байдлын салбар, нэгжийн холбоо зохион байгуулах хүн хүч, техник хэрэгслийг нэмэлтээр татан томилгоожуулна.

3.4.3. Байгууллагын салбар, нэгжүүд нь зэргэлдээх анги, салбарууд болон нэмэлтээр дайчлагдан ажиллаж буй бүлгүүдтэй 'Хүснэгт 2'-т тусгагдсан харилцаа холбооны сувгуудын дагуу харилцан ажиллагааны холбоог зохион байгуулж, мэдээлэл солилцооны тасралтгүй байдлыг хангана.

3.4.4. Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэхэд Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх 111 дүгээр ангийн нисдэг тэрэгний холбооны систем нь холбоо зохион байгуулах нэг төрлийн суваг болох бөгөөд нэн шаардлагатай тохиолдолд удирдлагын төвүүдтэй шууд холбогдох чухал хэрэгсэл болно.

3.4.5. Гамшгийн үед холбоо, мэдээллийн системийн зохион байгуулалт, шийдвэр гаргалт, дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа нь шаталсан бүтэц болон хариуцлагын түвшингээр зохион байгуулагдаж, нэгдсэн удирдлагын зарчмаар хэрэгжүүлнэ.

Хүснэгт 1. Холбооны системийн удирдлага

Зохион байгуулах	Шийдвэр гаргах	Дэмжлэг үзүүлэх
Улсын хэмжээнд		
Холбоо, мэдээллийн технологийн газар	Онцгой байдлын ерөнхий газрын удирдлагууд	Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх харьяа анги, салбар
Бүсийн хэмжээнд		
Бүсийн төвийн Онцгой байдлын газар, Шуурхай удирдлагын төв	Холбоо, мэдээллийн технологийн газар	Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх харьяа газар, анги, салбар
Аймаг, нийслэлийн хэмжээнд		
Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын холбооны нэгж	Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар	Онцгой байдлын ерөнхий газрын дэргэдэх харьяа газар, анги, салбар
Сум, дүүргийн хэмжээнд		
Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын холбооны нэгж	Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар	Бүсийн төвийн Онцгой байдлын газар
Онцгой байдлын байгууллагын анги, салбар, нэгжгүй суманд		

Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газрын холбооны нэгж	Аймаг, нийслэлийн Онцгой байдлын газар	Бүсийн төвийн Онцгой байдлын газар
--	---	------------------------------------

Дөрөв. Хүч, хэрэгслийн зохион байгуулалт

4.1. Гамшгийн үед холбоо зохион байгуулалтыг Холбоо, мэдээллийн технологийн газрын дарга удирдан зохион байгуулах бөгөөд шаардлагатай тохиолдолд түүнийг Холбоо зохион байгуулалтын хэлтсийн дарга орлон ажиллана.

4.2. Холбоог зохион байгуулах үйл ажиллагааг Онцгой байдлын ерөнхий газрын Холбоо, мэдээллийн технологийн газрын Холбоо зохион байгуулалтын хэлтсийн дарга, Мэдээллийн технологийн хэлтсийн дарга нар байнгын хяналтад авч, мэргэжлийн удирдлагаар хангаж ажиллана.

4.3. Холбоо, мэдээллийн технологийн газрын дарга, тус газрын Холбоо зохион байгуулалтын хэлтэс, Мэдээллийн технологийн хэлтэс, Үндэсний аврах бригад, нийслэлийн Онцгой байдлын газар, Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн 119 дүгээр анги, Уул уурхайн аврах 09 дүгээр анги, Агаараас эрэн хайх, аврах 111 дүгээр анги, орон нутгийн Онцгой байдлын газрын Холбоо, мэдээллийн технологийн нэгжийн нийт алба хаагч гамшгийн үеийн холбоог зохион байгуулах, техник хэрэгслийн хэвийн ажиллагааг хангана.

4.4. Онцгой байдлын ерөнхий газрын даргын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн “Шуурхай ажиллагаа зохион байгуулах журам”-ын 6 дугаар бүлэг “Албаны хэвлэмэл хуудас, холбогдох зардал, техник хэрэгслийг олгох” үүргийн дагуу Шуурхай удирдлага, зарлан мэдээллийн 119 дүгээр ангид байрлах холбоо, мэдээллийн техник хэрэгслийг татна.

4.5. Хэрэв гамшгийн үед бэлэн байдалд байх холбооны техник хэрэгсэл хүрэлцэхгүй болсон тохиолдолд хамгийн ойр байрлах гамшигт өртөөгүй Онцгой байдлын анги, байгууллагуудаас холбооны хүч хэрэгслийг Хавсралт 1-т заасны дагуу татан гаргана.

4.6. Үүрэн холбооны сүлжээгүй газар орон болон сүлжээ тасалдсан тохиолдолд сансрын холбоог ашиглах бөгөөд шаардлагатай тохиолдолд нэмэлтээр үүрэн холбооны сүлжээ үүсгэгч төхөөрөмжийг дэлгэн байгуулж, тухайн газар орноос утастай болон утасгүй сүлжээнд холбогдох боломжийг бүрдүүлнэ.

4.7. Байгууллагын харилцаа холбооны системүүд ажиллагаагүй болсон тохиолдолд бүтцийн нэгж тус бүр хоёроос доошгүй биет холбоочныг томилж, “Онцгой байдлын ерөнхий газрын бие бүрэлдэхүүний утас, гэрийн хаяг, цахим хаяг”-ийн дагуу зарлан мэдээлэл хүргэнэ.

4.8. Харилцаа, холбооны техник хэрэгслийн хяналт, судалгаанд үндэслэн төлөвлөгөөнд жил тутам тодотгол хийж, сэргээн засварлахад шаардлагатай сэлбэг, хэрэгслийг улсын төсөвт тусгуулна.

4.9. Мөн гамшгийн үед ашиглагдсан харилцаа холбооны техник хэрэгсэлд тухай бүр тодотгол хийж, шаардлагатай сэлбэг хэрэгслийг сэргээн засварлахаар улсын төсөвт тусгуулна.

4.9.10. Гамшгийн үед холбооны үүргийн дагуу Хүснэгт 2-т заасан холбоо, мэдээллийн тоног төхөөрөмжийг ашиглах бөгөөд гамшгийн төрөл, өртсөн бүс нутаг дахь холбооны сүлжээ, газар орны онцлогийг үнэлж, холбооны системийг сонгон ашиглана.

4.9.11. Холбооны системийг сонгон ашиглахдаа гамшгийн голомтын цар хүрээ, талбай хэмжээ болон үүрэг гүйцэтгэх алба хаагчийн тооноос шалтгаалж, тоног төхөөрөмжийг тоо хэмжээг тогтооно.

4.9.12. Гамшгийн голомтод 3 ба түүнээс дээш аймаг, анги, салбар үүрэг гүйцэтгэх тохиолдолд холбоо зохион байгуулах үйл ажиллагааг удирдах чиглүүлэх, техникийн бэлэн байдлыг хангах зориулалт бүхий холбооны хөдөлгөөнт бүлгийг шуурхай гаргана.

4.9.13. Нөгөөтээгүүр гамшгийн үед удирдлага зохион байгуулалтаар хангах хээрийн штаб байгууллагдсан тохиолдолд холбооны хөдөлгөөнт бүлгийг томилгоожуулах бөгөөд бүлэг нь 3-5 алба хаагчийн бүрэлдэхүүнтэй байна.

Хүснэгт 2. Холбооны сувагчлалын төрөл

д/д	Холбооны төрөл	Суваг	Гамшгийн төрөл										
			Ойн түймэр	Хээрийн түймэр	Объектын түймэр	Газар хөдлөлт	Үер	Зуд	Малын гоц халдварт өвчин	Хүний гоц халдварт өвчин	Хүчтэй цасан болон шороон шуурга	Тэсэрч дэлбэрлэх осол	Бусад
1	Телефон холбоо	Суурин холбоо /АТС/											
		Үүрэн холбоо											
		Сансрын холбооны утас											
2	Радио холбоо /Богино болон хэт богино долгионы/	Аналоги системийн радио станц (гар, машин, үүргэвчийн, дахин дамжуулах)											
		Тоон системийн радио станц											
3	Мэдээллийн сүлжээний дэд бүтэц	Төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ											
		Интернэтийн сүлжээ (суурин болон сансрын)											
		Интернэтийн сүлжээ үүсгэх төхөөрөмж (старлинк)											

4	Мэдээллийн систем	Дүрст хурлын систем											
		Теле хяналтын систем											
		Мэдээлэл солилцох систем											
		Мэдээллийн нэгдсэн сан											
5	Бусад төрлийн холбоо	Шуудан холбоо											
		Биет холбоочин											
		Нисгэгчгүй нисэх төхөөрөмж											
		Хөдөлгөөнт холбооны зангилаа											
6	Дагалдах хэрэгсэл	Зөөврийн цахилгаан үүсгүүр,											
		Зөөврийн батарей (ecoflow)											
		Гар болон үүргэвчийн радио станцын батарей											
		Жижиг хуруу батарей											
		Олон залгуур											
		Засвар үйлчилгээний багаж, сэлбэг хэрэгсэл											

4.9.14. Холбооны хөдөлгөөнт бүлэг нь гамшгийн голомтод холбоо зохион байгуулалтын системийг бүрдүүлж, техникийн бэлэн байдлыг ханган, тасралтгүй холбооны сүлжээ байгуулах үндсэн үүрэгтэй. Шаардлагатай тохиолдолд газар дээр нь холбооны тоног төхөөрөмжид оношилгоо хийж, засвар үйлчилгээ гүйцэтгэх зэрэг дараах арга хэмжээг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Гамшгийн голомтод холбоо, мэдээллийн системийн найдвартай, тасралтгүй ажиллагааг хариуцах;
- Түр болон байнгын дахин дамжуулах станц, антен суурилуулах, тохируулах, ажиллуулах;
- Үүрэн болон сансрын холбооны сүлжээ үүсгэх, ашиглах нөхцөлийг бүрдүүлэх;
- Гар болон суурин радио станцын тохиргоо, холболтыг гүйцэтгэх, ажиллагааг шалгах;
- Холбооны систем, техник хэрэгслийн доголдол, эвдрэл гэмтлийг илрүүлэн газар дээр нь засварлах, нөхөн сэргээх арга хэмжээ авах;
- Бие бүрэлдэхүүнд холбооны техник хэрэгслийн ашиглалт, анхан шатны оношилгоо хийх талаар заавар, зөвлөмж өгөх.

ТАВ. ХОЛБООНЫ БЭЛЭН БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Холбоо зохион байгуулалтын бэлэн байдлыг хангах талаар

д/д		Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Хариуцах нэгж	Хамтран хэрэгжүүлэх нэгж
1	Холбоо зохион байгуулалтын чиглэлээр	Холбооны хүч хэрэгсэл (<i>радио, сансрын холбоо, АТС, үүрэн, бусад</i>) болон түүнийг дайчлан гаргах судалгааг тодотгох	II, IV улирал	ХЗБХ	ТОНОБГ
2		“Яаралтай цугларах дохио”-оор ажиллах бүдүүвчийг тодотгох	I-IV улирал	119-р анги	ТОНОБГ
3		Гамшгийн голомтоос холбоо зохион байгуулах төлөвлөлт бүдүүвчийг тодотгох	II, IV улирал	ХЗБХ	119-р анги
4		Холбоо, зарлан мэдээлэл, мэдээллийн технологийн чиглэлийн алба хаагчдын судалгааг тодотгох	II, IV улирал	ХЗБХ	ТОНОБГ
5		Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгсэл, тоног төхөөрөмжийн засвар үйлчилгээг тусгай график төлөвлөгөөний дагуу зохион байгуулах	II, III, IV улирал	ХЗБХ	ТОНОБГ 119-р анги
6		Шуурхай штабуудын удирдлагын болон харилцан ажиллагааны үед ашиглах радио холбооны техник хэрэгслийн бэлэн байдлыг шалгах	I-IV улирал	ХЗБХ	ТОНОБГ
7		Зарлан мэдээллийн хөдөлгөөнт удирдлагын автомашины техникийн бэлэн байдлын хангах	I-IV улирал	119-р анги	ХЗБХ
8		Холбооны хөдөлгөөнт зангилааны техникийн бэлэн байдлыг хангах	II, IV улирал	ТОНОБГ	ХЗБХ
9		Салбар нэгжийн утасны жагсаалтыг тодотгох	I-IV улирал	119-р анги	ХЗБХ
10		Салбар нэгжийн холбоочдын мэдээллийг тодотгох			
11		Богино болон хэт богино долгионы радио станцын тархалтын шинжилгээг жилд нэг бүсээр хийх	Жилдээ	ХЗБХ	ТОНОБГ
12		Радио холбооны системд бүхэлд нь үр ашгийн шинжилгээ хийх	3 жил тутамд	ХЗБХ	ГСҮХ
13		Тоног төхөөрөмж болон антены байгууламжийн гамшигт тэсвэртэй байдлыг дээшлүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Жилдээ	ХЗБХ	ТОНОБГ
14	Мэдээллийн технологийн чиглэлээр	Суурин удирдлагын төвийн интернэт болон интранет сүлжээ ашиглалтын бэлэн байдлыг хангах	I-IV улирал	МТХ	ТОНОБГ
15		Суурин удирдлагын төвийн дуу, дүрс дамжуулах цахим холболтын техникийн бэлэн байдлыг хангах	I-IV улирал	ТОНОБГ	МТХ

16		Суурин болон хөдөлгөөнт штабуудын интернэт сүлжээний бэлэн байдлыг хангах	I-IV улирал	ТОНОБГ	МТХ
17		Төв суурин газрын замын хяналтын камерыг Гамшгийн үед хянах боломжтой байхаар бүрдүүлэх	I-IV улирал	ТОНОБГ	МТХ
18		Гал түймэр унтраах удирдагчийн энгэрийн камер болон хяналтын нисгэгчгүй нисэх төхөөрөмжийн бичлэгийг удирдлагын төв рүү шууд дамжуулах боломжийг бүрдүүлэх	I-IV улирал	ТОНОБГ	ХЗБХ, МТХ
19	Сургалт бэлтгэлийн чиглэлээр	Төрийн цэргийн болон хууль сахиулах тусгайлсан чиг үүрэг бүхий байгууллагуудтай харилцан ажиллагааны холбооны хамтарсан дадлага сургууль хийх	Жилдээ	ГХСГ	ХЗБХ
20		Бүсийн хэмжээний Онцгой байдлын анги, байгууллагын холбоочдын бүсчилсэн сургалтыг зохион байгуулах	Жилдээ	ГХСГ	ХЗБХ
21		Төв, орон нутгийн Онцгой байдлын байгууллагын холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн нарын сургалтыг зохион байгуулах	2 жил тутам	ГХСГ	ХЗБХ
22		Аналоги болон тоон холбооны ашиглалт, засвар үйлчилгээний сургалтыг зохион байгуулах	2 жил тутам	ГХСГ	ХЗБХ
23	Хангалтын чиглэлээр	Холбоо, зарлан мэдээллийн техник хэрэгслийн хангалтын төсвийг улсын төсөвт тусгуулах	Жилдээ	ХМТГ САТГ	ТОНОБГ
24		Холбооны үүргийн дагуу бүх түвшинд бие бүрэлдэхүүнийг холбоогоор бүрэн хангах, техник хэрэгслийн техникийн бэлэн байдлыг хангах	I улирал	ХМТГ САТГ	ТОНОБГ

Товчилсон үгний тайлбар:

ХМТГ	Холбоо, мэдээллийн технологийн газар
ТОНОБГ	Төв, орон нутгийн Онцгой байдлын газар
ХЗБХ	Холбоо, зохион байгуулалтын хэлтэс
МТГ	Мэдээллийн технологийн хэлтэс
ГХСГ	Гамшгаас хамгаалах сургалтын газар
ГСҮХ	Гамшиг судлалын үндэсний хүрээлэн

5.2. Гамшгийн үед Онцгой байдлын байгууллагын хэрэгжүүлэх арга хэмжээ

д/д	Авч хэрэгжүүлэх арга хэмжээ	Хариуцах нэгж		119-р анги	ҮАБ (Холбооны тусгай бүлэг)	УУА 09-р анги	Бүсийн төвийн ШУЗМТ	ТОНОБГ (ХЗМХМ, ДХА)
		ХЗБХ	МТХ					
1.	Гамшиг, аюулт үзэгдлийн мэдээг ООГХ, ЦУОШГ-аас хүлээн авч, салбар нэгжүүдэд дамжуулах			Ч+00:00-00:05				
2.	Гамшиг, аюулт үзэгдэл, ослын нөхцөл байдлын							

	мэдээг хүлээн авч, дээд шатны удирдлагад танилцуулах			Ч+00:05-00:20	
3.	Салбар, нэгжүүд харилцаа холбооны системийг байнгын хүлээн авалтад шууд шилжүүлнэ. Үүнд: богино долгионы радио тор №101, хэт богино долгионы радио тор №201, сансрын холбооны утас, сүлжээ үүсгэгч г.м.			Ч+00:05-00:10	
4.	Төрийн цэргийн болон хууль сахиулах байгууллагуудын харилцан ажиллагааны радио тор №001-ийг идэвхжүүлэх			Ч+00:05-00:10	
5.	Бие бүрэлдэхүүн яаралтай цуглар дохиог хүлээн авч, ажлын байранд цуглах			Ч+00:20-01:10	
6.	Анхдагч мэдээлэлд дүн шинжилгээг хийх, цагийн байдлыг үнэлэх			Ч+01:10-01:30	
7.	Холбоо, мэдээллийн системийн хүч хэрэгслийг тодотгох			Ч+01:30-01:40	
8.	Гамшигт өртсөн бүс нутаг дахь холбооны сүлжээ, газар орны онцлогийг үнэлж, холбооны системийг дэлгэх хугацааг тооцсоны үндсэн дээр холбоог зохион байгуулах арга хэмжээг авах			Ч+01:40-аас тухай бүр	
9.	Хөдөлгөөнт удирдлагын төвийн холбооны хүч хэрэгсэл, эрчим хүчний нөөц, генератор бэлэн байдлыг тодотгох			Ч+01:40-02:10	
10.	Холбооны техник хэрэгсэл хүрэлцэхгүй болсон тохиолдолд хамгийн ойр байрлах Онцгой байдлын салбар, нэгжээс холбооны хүч хэрэгсэл (Хавсралт 1)-ийг татан оролцуулах			Ч+02:10-02:20	
11.	Хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны зааварчилгааг мөрдлөг болгох, хяналт тавих			Ч+02:10-02:20	
12.	Удирдлагын шийдвэрийн дагуу гамшигт өртсөн бүс нутагт харилцаа холбоо тогтоох боломжгүй тохиолдолд АЭХА 111 дүгээр ангийн нисдэг тэргээр холбооны хүн, хүч хэрэгслийг дайчлах			Ч+02:20-06:20	
13.	Гамшгийн үеийн радио холбоог бүх түвшинд радио тор үүсгэн (Хавсралт 3) зохион байгуулах			Ч+01:40-01:50	
14.	Төрийн цэргийн болон хууль сахиулах			Ч+01:40-01:50	

	байгууллагуудтай төрийн мэдээллийн нэгдсэн сүлжээ (Jtsi, Rocket)-ээр цахим холболтыг (Хавсралт 2) зохион байгуулах			
15.	Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэх холбооны хөдөлгөөнт бүлгийг гаргах	Ч+01:50-02:50 		
16.	Холбоочин нь анги, салбарын байрлалаас гарснаас хойш 2 цаг тутам, шаардлагатай тохиолдолд тухай бүр холбоонд орох			Тухай бүр 
17.	Холбоо тогтоох зай хэмжээг нэмэгдүүлэх, сүлжээ үүсгэх дахин дамжуулах төхөөрөмжүүдийг газар орны нөхцөлд нийцүүлэн байршуулах			Тухай бүр 
18.	Гамшгийн голомтоос харилцаа холбооны боломжит сувгаар мэдээ, мэдээллийг тогтоосон цагуудад дээд шатны байгууллагатай солилцох	Тухай бүр 		
19.	Холбооны ажиллагааг хянах, тасралтгүй байдлыг хангах холбооны хөдөлгөөнт бүлгийг томилгоожуулах	Тухай бүр 		
20.	Гамшгийн голомтод үүрэг гүйцэтгэж байгаа холбоо хөдөлгөөнт бүлэг нь харилцаа холбооны боломжид бүх сувгийг хүлээн авалтад авна			Тухай бүр 
21.	Томилгоот үүрэг гүйцэтгэж буй бие бүрэлдэхүүнд ар тал хангалтыг зохион байгуулах. Үүнд: хоол хүнс, байр сууц, шатах тослох материал г.м.	Тухай бүр 		

Зургаа. Харилцаа холбоог сэргээн засварлах арга хэмжээг зохион байгуулах

6.1. Үүссэн нөхцөл байдалтай уялдуулан харилцаа холбооны систем, дэд бүтэц, техник хэрэгсэлд эвдрэл гэмтэл, доголдол үүссэн тохиолдолд дараах байдлаар сэргээн засварлах ажиллагааг зохион байгуулна. Үүнд:

6.1.1. Харилцаа холбооны техник хэрэгслийн үйл ажиллагаа доголдсон эсэхийг цаг алдалгүй тогтоох, ашиглалтын үнэлгээг хийх;

6.1.2. Систем, техникийн доголдол, эвдрэл гэмтлийг засварлаж, хэвийн ажиллагааг сэргээх чиг үүрэг бүхий инженер, техникийн алба хаагчдыг Хүснэгт 3-т зааснаар томилгоожуулж, шаардлагатай тохиолдолд бусад байгууллагаас нэмэлт хүч, хэрэгслийн дэмжлэг авах;

6.1.3. Нэн түрүүнд ашиглаж болох холбоо, мэдээллийн систем, техник хэрэгслийг тодорхойлж, харилцан ажиллагааны холбоог тасралтгүй зохион байгуулах;

6.1.4. Харилцаа холбоо бүрэн тасарсан тохиолдолд дараах дарааллаар сэргээнэ.

- радио холбоо,
- сансрын холбоо,
- цахилгаан тэжээл,
- шилэн кабель,
- үүрэн холбоо,
- цахилгаан холбоо,

6.1.5. Мэдээлэл, харилцаа холбооны гамшгаас хамгаалах улсын алба, мэргэжлийн ангиудтай уялдан ажиллах, тэдгээрийн гамшгаас хамгаалах бэлэн байдлын төлөвлөгөөг идэвхжүүлэх.


Хүснэгт 3. Холбоо техник хэрэгслийг засварлах, сэргээх инженер, техникийн алба хаагчид

д/д	Байгууллага	Бүтцийн нэгж	Алба тушаал	Алба хаагч
1	Онцгой байдлын ерөнхий газар	Холбоо зохион байгуулалтын хэлтэс	Радио холбооны ашиглалт хариуцсан мэргэжилтэн	1
			Харилцаа холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
		Мэдээллийн технологийн хэлтэс	Мэдээллийн сүлжээний удирдлага, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн	1
			Кибер аюулгүй байдлын эрсдэл, дүн шинжилгээ хариуцсан мэргэжилтэн	1
2	Нийслэлийн Онцгой байдлын газар	Шуурхай удирдлагын хэлтэс	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
3	Үндэсний аврах бригад	Холбоо, зарлан мэдээллийн бүлэг	Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
			Холбооны засварын техникч	1
4	ШУЗМТ 119 дүгээр анги		Холбооны засварын бүлэг	3
5	УУАА 09 дүгээр анги		Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1
6	АЭХА 111 дүгээр анги		Холбоо, зарлан мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	1

**ГАМШГИЙН ҮЕД ТӨВ, ОРОН НУТГИЙН ОНЦГОЙ БАЙДЛЫН БАЙГУУЛЛАГЫН ХОЛБООНЫ ХҮЧ ХЭРЭГСЛИЙГ ТАТАН
ОРОЛЦУУЛАХ ХУВААРЬ**

Д/д	Бүсүүд	Газар хөдлөлт гарсан аймаг	Нэмэлтээр хамтран ажиллах аймаг алслагдсан зай (км)			
			I	II	III	IV
1	Улаанбаатар бүс	Улаанбаатар хот	Төв аймаг	Дархан-Уул аймаг	Дундговь аймаг	Орхон аймаг
2	Хангайн бүс	Архангай аймаг	Хөвсгөл аймаг 435 км	Өвөрхангай аймаг 252 км	Булган аймаг 282 км	ҮАБ, НОБГ
3		Баянхонгор аймаг	Өвөрхангай аймаг 213 км	Говь-Алтай аймаг 384 км	Завхан аймаг 209 км	ҮАБ, НОБГ
4		Өвөрхангай аймаг	Баянхонгор аймаг 209 км	Архангай аймаг 252 км	Булган аймаг 374 км	ҮАБ, НОБГ
5	Баруун бүс	Ховд аймаг	Баян-Өлгий аймаг 218 км	Увс аймаг 253 км	Говь-Алтай аймаг 439 км	ҮАБ, НОБГ
6		Баян-Өлгий аймаг	Ховд аймаг 218 км	Увс аймаг 245 км	Завхан аймаг 642 км	ҮАБ, НОБГ
7		Говь-Алтай аймаг	Ховд аймаг 439	Баянхонгор аймаг 384 км	Завхан аймаг 462 км	ҮАБ, НОБГ
8		Завхан аймаг	Хөвсгөл аймаг 430 км	Баянхонгор аймаг 209 км	Архангай аймаг 256 км	ҮАБ, НОБГ
9		Увс аймаг	Ховд аймаг 253 км	Баян-Өлгий аймаг 245 км	Завхан аймаг 267 км	ҮАБ, НОБГ
10	Хойд бүс	Булган аймаг	Орхон аймаг 60 км	Дархан-Уул аймаг 180 км	Архангай аймаг 282 км	ҮАБ, НОБГ
11		Орхон аймаг	Булган аймаг 60 км	Дархан-Уул аймаг 180 км	Сэлэнгэ аймаг 279 км	ҮАБ, НОБГ
12		Хөвсгөл аймаг	Архангай аймаг 169 км	Булган аймаг 330 км	Орхон аймаг 390 км Завхан аймаг 430 км	ҮАБ, НОБГ
13	Зүүн бүс	Дорнод аймаг	Сүхбаатар аймаг 193 км	Хэнтий аймаг 324 км	Говьсүмбэр аймаг 500 км	ҮАБ, НОБГ
14		Сүхбаатар аймаг	Дорнод аймаг 193 км	Хэнтий аймаг 220 км	Говьсүмбэр аймаг 458 км Дорноговь 430 км	ҮАБ, НОБГ
15		Хэнтий аймаг	Сүхбаатар аймаг 220 км	Говьсүмбэр аймаг 223 км	Дорнод аймаг 324 км	ҮАБ, НОБГ
16	Говийн бүс	Өмнөговь аймаг	Дундговь аймаг 332 км	Өвөрхангай аймаг 372 км	Баянхонгор аймаг 507 км	ҮАБ, НОБГ
17		Дорноговь аймаг	Говьсүмбэр аймаг 345 км	Сүхбаатар аймаг 430 км	Дундговь аймаг 497 км	ҮАБ, НОБГ
18		Дундговь аймаг	Говьсүмбэр аймаг 237 км	Төв аймаг 263 км	Өвөрхангай аймаг 324 км	ҮАБ, НОБГ
19		Говьсүмбэр аймаг	Төв аймаг 223 км	Дундговь аймаг 208 км	Дорноговь аймаг 244 км	ҮАБ, НОБГ
20		Дархан-Уул аймаг	Сэлэнгэ аймаг 98 км	Орхон аймаг 180 км	Булган аймаг 260 км	ҮАБ, НОБГ
21	Төвийн бүс	Төв аймаг	НОБГ 43 км ҮАБ 43 км	Дархан-Уул аймаг 266 км Сэлэнгэ аймаг 363 км	Дундговь аймаг 232 км Дорноговь аймаг 266 км Говьсүмбэр аймаг 204 км	Хэнтий аймаг 313 км
22		Сэлэнгэ аймаг	Дархан-Уул аймаг 98 км	Орхон аймаг 279 км	Булган аймаг 338 км Төв аймаг 363 км	ҮАБ, НОБГ

ЦАХИМ МЭДЭЭЛЭЛ ДАМЖУУЛАХ БҮДҮҮВЧ



ХОЛБОО ЗОХИОН БАЙГУУЛАХ БҮДҮҮВЧ

Иргэд	ААНБ	ГХУА ЭХАА	ОБГ,Х	НОбГ	ҮАБ		ОБЕГ АУШтаб		ТЦБХСБ		МУЗГ, ҮАБЗ
						Төвлөрсөн зарлан мэдээлэл		Төвлөрсөн зарлан мэдээлэл			
						БД-ны радио тор		ХА-ны БД-ны радио тор №101			
						ХБД-ны радио тор /тоон/					
						ХБД-ны радио тор /аналог/		ХА-ны ХБД-ны радио тор №201			
						Цахим дүрс холболт		ТНХС дүрс, чат холболт			
						МЦХ-ны АТС болон үүрэн холбоо		Нууцлагдсан телефон			
						Сансрын холбоо /иридиум, старлинк/		Сансрын холбоо /иридиум, старлинк/			

---oOo---